

УАНС – НЭЗСС Бүсийн Хүрээ

Байршил:

Бүсийн

Төслийн дугаар:

50223

Бизнесийн салбар:

Санхүүгийн байгууллагууд

Мэдэгдлийн төрөл:

Хувийн

Байгаль орчны ангилал:

FI

Захирлуудын зөвлөлд танилцуулах тов:

20 Jun 2018

Төлөв байдал:

Үзэл баримтлал нь хянагдсан.

Англи хэл дээрх ТХББ-ийг нийтэд танилцуулсан огноо:

2018 оны 5-р сарын 21

Төслийн Танилцуулга

Энэхүү төсөл нь ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын санхүүгийн байгууллагуудад тус Банкны уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох чиглэлийн хөрөнгө оруулалтад зориулсан зээлийн шугамуудаар хангадаг Ногоон Эдийн Засгийн Санхүүжилтийн Сан (НЭЗСС)-гаар дамжуулан хүргэх ЕСБХБ болон Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гийн санхүүжилтийн шинэ багц юм. Төсөл нь 400 сая ам.долларын санхүүжилтийн багцын хуваарилалтаас бүрдэх ба үүний 300 сая ам.доллар нь Банкны ердийн эх үүсвэрээс, 100 сая ам.доллар нь Армен, Египет, Гүрж, Йордан, Молдав, Монгол, Марокко, Серби, Тажикистан, Тунис улсуудад байрших НЭЗСС-гийн хүрээнд НУАС-гаас олгогдоно. Төслийн санхүүжилтийг Ногоон Эдийн Засгийн Шилжилтийг дэмжсэн, цаг уурын өөрчлөлтийг бууруулах, цаг уурын өөрчлөлтөнд нийцүүлэн дасан зохицоход чиглэсэн хөрөнгө оруулалтанд зориулан хувийн болон төрийн хэвшил (бизнесүүд, хувь хүмүүс, орон сууцны нэгдэл, гүйцэтгэл өндөртэй технологийн ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид болон орон нутгийн үйлчилгээний компаниуд)-д дамжуулан зээлдүүлэх зорилгоор эрх бүхий улс орнууд дахь шаардлага хангасан дотоодын санхүүгийн байгууллагуудад олгоно.

Төслийн Зорилго

Хүрээ нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөнд нийцүүлэн дасан зохицох санхүүжилтийн одоогийн зах зээлийг мэдэгдэхүйц хэмжээгээр өсгөн нэмэгдүүлэх буюу эсвэл шинэ зах зээл бий болгоход хувь нэмэр оруулах болно. Ингэснээр Банкны Ногоон Эдийн Засгийн Шилжилтийн Арга Барилын стратегийн

зорилгыг ялангуяа Банкны зүгээс шууд хүрэх боломжгүй жижиг хэмжээний төслүүдэд хүрэх замаар хангахад хувь нэмэр оруулах юм. Хүрээ нь аж үйлдвэрийн, худалдаа арилжааны, орон сууцны, тээврийн болон хөдөө аж ахуйн салбаруудын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, мөн уур амьсгалын өөрчлөлтөнд нийцүүлэн дасан зохицох чиглэлд өргөтгөх, томруулах боломжтой 13,000 гаруй төслүүдийн санхүүжилтэнд дэмжлэг үзүүлэх хэлбэрээр зах зээлийг өргөтгөнө. Энэ нь технологийн ханган нийлүүлэлтийн сүлжээний дагууд тулгардаг олон тооны зах зээлийн саад бэрхшээлүүдийг шийдвэрлэхээс гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын боломжийг нээж өгнө.

Шилжилтийн Нөлөөлөл

Энэхүү Хүрээ нь ЕСБХБ-ны хөрөнгө оруулалт хийгдсэн улс орнуудын дундаас сонгосон 10 оронд тэдгээрийн эдийн засгийг нүүрстөрөгчийн хий ихээр ялгаруулдаг, цаг уурын өөрчлөлтөнд эмзэг буюу эсвэл байгаль орчинд хор хөнөөл учруулж бохирдуулах зам дээр түгжигдэхээс урьдчилан сэргийлснээр байгаль орчны хувьд тогтвортой, нүүрстөрөгчийн хий бага ялгаруулах, цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицсон эдийн засагт шилжих үйл явцыг дэмжинэ. Ингэхдээ өндөр үзүүлэлттэй “уур амьсгалын” технологи болон шийдлүүдийг санхүүжүүлэх санхүүгийн зуучлагчдад хөрөнгө санхүүжилт олгох, нөү-хау нэвтрүүлэх замаар хийж гүйцэтгэнэ.

Харилцагчийн Мэдээлэл

Зээлдэгчид нь эрх бүхий улс орнуудад үйл ажиллагаа явуулж буй банкууд, бичил санхүүгийн байгууллагууд, лизингийн компаниуд болон технологийн ханган нийлүүлэгчдээс бүрдсэн дотоодын санхүүгийн байгууллагууд байна.

ЕСБХБ-ны Санхүүжилтийн Дүн

300,000,000.00 ам.доллар

Төслийн Нийт Өртөг

400,000,000.00 ам.доллар

Байгаль орчин, Нийгэмд үзүүлэх Нөлөөллийн Хураангуй

FI (БОНБ 2014) ангилалд багтсан. Энэхүү Хүрээнд хамрагдах бүх Оролцогч Санхүүгийн Байгууллагууд (ОСБ-ууд) ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн 2, 4, 9 дэх шаардлагуудыг дагаж мөрдөх, санхүүгийн байгууллагуудад зориулсан ЕСБХБ-ны Байгаль орчны болон Нийгмийн Эрсдэлийн Удирдлагын Журмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлэх, мөн дэд төслүүд ба тэдгээрийн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох чиглэлд үзүүлсэн ач холбогдлын талаарх тайланг багтаасан Санхүүгийн Байгууллагуудын Тогтвортой Байдлын Индексээр дамжуулан жил тутмын Байгаль орчин болон Нийгмийн асуудлаарх тайлангаа Банкинд илгээх шаардлагатай. Энэхүү Хүрээнд хамрагдан санхүүжилт авсан Үр ашиг хүртэгчид байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал ба хөдөлмөрийн стандартын үндэсний шаардлагуудыг дагаж мөрдөх, Бодлогын баримт бичгийн дагуу уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төслүүдэд тавигддаг Байгаль орчны болон Нийгмийн шаардлагын шалгуур үзүүлэлтүүдийг хангах ёстой. Энэ тухай ЕСБХБ-ны гэрээлэн ажиллуулсан Санхүүгийн Зөвлөх ОСБ-уудад мэдэгдэнэ.

Техникийн Хамтын Ажиллагаа

Энэхүү Хүрээг 23 сая орчим ам.долларын хэмжээтэй, чадавхи бэхжүүлэх, маркетинг, төслийн үнэлгээ болон ерөнхий хяналт шинжилгээ, тайлагнах үйл ажиллагааны чиглэлүүдээс бүрдсэн техникийн хамтын ажиллагааны багцаар дэмжинэ. Ногоон зээлийн бүтээгдэхүүний загвар шийдэл, маркетингэд хамаарах жендэрийн онцлогтой эрэлт нийлүүлэлтэнд тулгарч буй саад бэрхшээлүүдийг арилгахад туслах зорилгоор жендэрийн бүрэлдэхүүн хэсгийг мөн тусад нь зэрэг хэрэгжүүлнэ.

Бизнесийн Боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээллийг [EBRD Procurement](#) вэб хуудаснаас авна уу:

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий Лавлагаа

ЕСБХБ-ны төслүүдийн худалдан авах ажиллагаанаас бусад асуудлаар лавлагаа мэдээлэл авах:

Утас: +44 20 7338 7168;

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)

Олон нийтийн мэдээллийн бодлого (“ОНМБ”) нь ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийг хэрхэн ил болгох, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах журмыг тодорхойлдог. Төрийн хэвшлийн захирлуудын зөвлөлийн тайлан илтгэл авах хүсэлтийг хэрхэн гаргах талаарх мэдээллийг доорх холбоосоор ОНМБ-ын вэб хуудаснаас авна уу.

[ОНМБ-ын бичвэр](#)

Төслийн гомдлын газар (ТГГ)

Төслийн Гомдлын Газар (“ТГГ”) нь ЕСБХБ-ны эгэх хариуцлагын механизм юм. Энэ нь ЕСБХБ-ны санхүүжилттэй аливаа төсөл байгаль орчинд буюу нийгэмд хор хохирол учруулсан эсвэл учруулж болзошгүй гэж үзсэн хувь хүн болон байгууллагын зүгээс гаргасан гомдлыг хараат бусаар хянан үзэх боломж олгодог.

Гомдол хэрхэн гаргах талаар мэдээлэл авахыг хүсвэл ТГГ-ын [Project Complaint Mechanism](#) вэб хуудсанд хандана уу. ТГГ-ын ажилтан (pcm@ebrd.com) гомдол гаргах, гомдлыг бүртгэх ба гомдлын шаардлагын шалгуурт хэрхэн нийцүүлэх тухай асуудлаар **ТГГ-ын Үйл ажиллагааны журам (PCM Rules of Procedure)-ын** дагуу таны асуултанд хариулахад бэлэн байна.